ГОМДЛЫН АГУУЛГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

| № | Байгууллагын нэр | Тухайн байгууллагад ирүүлсэн нийт өргөдөл, гомдол | | өргөдөл,гомдлын агуулга | тоо | | хувь | | Гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2024 он | 2025 он | | 2024 | 2025 | 2024 | 2025 | |
| 1 | Эрүүл мэндийн газар | 206 | 187 | | 4 | 7 | 0.02 | 0.04 | |
| 1 | Иргэн Баярмаа | | | Миний эмээ 91 настай. Учралтбаяр ӨЭМТ-өөс эмнэлгийн үйлчилгээ авахаар 13:00-15:00 цаг өнгөртөл хүлээхэд эмч нар үзлэг хийсэнгүй. Ахмадын эмч нь жижүүрт гарсан гэж хэлээд буусан. Өндөр настай хүнийг 2 цаг гаруй хүлээлгээд эмчийн үзлэг хийхгүй буцаасанд их гомдолтой байна | | | | | Иргэн 91 настай, өмнө нь хараа муу шалтгаанаар группэд хамрагдаж байсан, одоо болор солиулах хагалгаа хийлгэсэн тул хасагдсан. Иймд иргэнийг холбогдох хууль, журмын дагуу БОЭТ-ийн ахмадын эмчид хандан үзлэг, зөвлөгөө авч эрүүл мэндийн магадлан хэлэлцэх хуралд оролцох боломжтой талаар мэдээлэл өгсөн. |
| 2 | Иргэн Б.Эрдэнэбаяр | | | Амгалан захиралтай 14 дүгээр сургуулий 6г ангийн багш Туяа миний хүүхдэд ХПВ вакцин хийлгэсэн тул гомдолтой байна. | | | | | Дархлаажуулалтын үндэсний товлолд орсон вакцин нь заавал хийлгэх вакцин тул зөвшөөрлийн хуудаст эцэг, эх, асран хамгаалагчаас гарын үсэг авдаггүй, вакцин хийх тухай мэдээллийг боловсрол болон эрүүл мэндийн байгууллагаас өгдөг. Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцины хувьд дархлаажуулалтын үндэсний товлолд шинээр нэвтэрч байгаа вакцин учраас эцэг, эх, асран хамгаалагчдад тухайн вакцины талаарх мэдээллийг агуулсан таниулах хуудаст танилцсан тухай гарын үсэг зуруулж байгаа юм.<br>Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар 2024 оны 11 сараас эхлэн улсын хэмжээнд 94,000 гаран хүүхэд хамрагдаад байна. Тус вакцин нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрөлтэй, хүний |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Иргэн Уянга | | | Дурааараа сахуу татрангийн вакцин хийж байгаад гомдолтой байна. | | | | | Улсын Их Хурлын 2023 оны 10 сарын 27-ны өдөр дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакциныг дархлаажуулалтын үндэсний товлолд оруулсан. Засгийн газрын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн 472 дугаар тогтоолоор дархлаажуулалтын үндэсний товлолыг баталж, 9 төрлийн 13 өвчнөөс сэргийлэх вакциныг хэрэглэж байна.<br>Манай улс сахуу, хөхүүл ханиад, татран гийн хавсарсан гуравт вакциныг 1967 оноос дархлаажуулалтын үндэсний товлолд нэвтрүүлэн хэрэглэж ирсэн. 2005 оноос тавт вакцин буюу сахуу, хөхүүл ханиад, татран, В вируст гепатит, ХиВ-ийн эсрэг хавсарсан вакцин хэлбэрээр 2,3,4 сартай хийж, дархлал сэргээх тунг 7 болон 15 насанд хийдэг.<br>Энэхүү вакцины үр дүнд манай улсад сахуу хөхүүл ханиадны тохиолдол сүүлийн 20 жилд, татрангийн тохиолдол сүүлийн 10 жил бүртгэгдээгүй байна. Эх нярайн татран өвчнийг устгасныг судалгаагаар баталгаажуулсан.<br>Дархлаажуулалтын үндэсний товлолд орсон вакцин нь заавал хийлгэх вакцин тул зөвшөөрлийн хуудаст эцэг, эх, асран хамгаалагчаас гарын үсэг авдаггүй, вакцин хийх тухай мэдээллийг боловсрол болон эрүүл мэндийн байгууллагаас өгдөг болно. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Иргэн Нармандах | | | Calm Лоужинд хоол идсэн бөгөөд хөгц мөөгөнцөртэй слад идэж гүйлгэж бөөлжсөнд тухайн газарт гомдолтой байна. | | | | | Тухайн хөгц нь хоол үйлдвэрлэлд хүлээн зөвшөөрөгдсөн шинжилгээний бичигтэй бүтээгдэхүүн хэрэглэж байсан. Тус газарт хоолны меню-д оруулахыг зөвлөж захиалагч мэдээллийг хүргэж өгч ажиллахыг зөвлөж тухайн өдрийн иргэний хоолны төлбөрт төлсөн мөнгийгбуцаан олгож гомдлыг бүрэн барагдуулсан |
| 5 | Иргэн Сосорбарам | | | 4-5 дугаар байрны хажууд байрлах хүнсний дэлгүүрээс СҮҮ ХХК-ны 2ш сүү авсан. 1ширхэг сүүгээр цай чанахад гашилсан байсанд гомдолтой байна. | | | | | Сүү ХХК-д тухайн иргэний гомдлыг танилцуулж иргэн Сосорбарамд шинээр 1ш шинэ сүү олгож гомдлыг барагадуулсан. |
| 6 | Иргэн Дэлгэрмаа | | | Ачит эмнэлэг дотроо жорлонтой өрөө 90000 төгрөг, жорлонгүй өрөө 70000 төгрөгөөр хэвтэн эмчлүүлж байна. Өндөр настай хүнээс 630000 төгрөгийн эмчилгээний хөлс авч байна. Эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөхгүй байгаад гомдолтой байна. | | | | | Ж.Санжааг хэвтүүлэн эмчлүүлэх үед тухайн эмнэлгийн ЭМД-ын хөнгөлөлтөөр эмчилгээ үйлчилгээ үзүүлэх хязгаар хэтэрсэн байсан тул "Эрдэнэт Ачит нар" ХХК-ний захирлын тушаалаар баталсан тарифыг танилцуулж уг тарифыг 30%-иар хөнгөлж төлбөр тооцоог хийлгэн хэвтүүлэн эмчилсэн байна. Энэ тухай тайлбарыг Ачит нар эмнэлгээс албан бичгээр авч С.Дэлгэрмаатай 99355878 утсаар холбогдож учрыг тайлбарлан танилцууллаа. Ачит нар эмнэлгээс тухайн иргэнтэй утсаар холбогдож тайлбар хийсэн байна. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Иргэн Амаржаргал | | | Их хаадын цуваа барилгын ард байрлах Оюун эмнэлэг нь эмнэлгийн хог хаягдал / сприц/ ил задгай буюу манай хашаанд хаяж байгаад гомдолтой байна.Шалгаж арга хэмжээ авч өгнө үү. | | | | | Иргэнээс ирүүлсэн "Оюу эмнэлэг эмнэлгийн хог хаягдлаа манай хашаанд ил задгай хаядаг" тухай гомдлын дагуу 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр газар дээр нь шалгалт хийхэд гомдолтой хамт хавсаргасан Булаг Ургац 1 3 тоот гэх хаяг олдоогүй, Булаг багийн 1-3- тоот хаягт "Амаржаргал" нэртэй иргэн амьдардаггүй харин ургац 1-3 тоот хаягт нийтийн байр байрлаж байв. |
| | дүн | 206 | 187 | | 4 | 7 | 0.02 | .0.04 | |